

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр, Мягмар гараг*

***Хуралдааны тэмдэглэлийн агуулга***

***Хуралдааны товч тэмдэглэл:*** 1-3

***Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:*** 4-11

---

<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай/</i>	4-5
<i>2.“Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	5-11

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны  
04 дүгээр сарын 18-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 30 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар;  
Чөлөөтэй: Х.Ганхуяг, Т.Доржханд, С.Чинзориг;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг “Хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ц.Цэрэнпунцаг:** “Хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын саналыг гаргав.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** “Хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 14 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.** “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, ахлах мэргэжилтэн Б.Мөнхбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, М.Оюунчимэг, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 27 минут үргэлжилж, 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 14 цаг 57 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
14 цаг 30 минут.

### **ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ц.Цэрэнпунцаг:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Жамбалын Ганбаатар гишүүн өвчтэй байгаа, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн өвчтэй, Тогмидын Доржханд гишүүн чөлөөтэй, Болдын Жавхлан гишүүн гадаадад томилолттой, Чимэдбаатарын Хүрэлбаатар гишүүн гадаадад томилолттой байна. Ингээд бусад гишүүд хүрэлцэн ирсэн байна. Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 55.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хороогоор хуралдах хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1.Хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. Засгийн газрын тусгай сангуудын асуудлаар хяналт шалгалт явуулах тухай Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн санаачилгаар боловсруулсан. 2.Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлгийг хийнэ. Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай/**

Хэлэлцэх асуудал 1.Хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хийе. Ажлын хэсгийн зорилго, бүрэлдэхүүний талаарх тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь. 1.Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сар сарын 13-ны өдөр баталсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Х.Ганхуяг Улсын Их Хурлын гишүүн, гишүүд Б.Баттөмөр Улсын Их Хурлын гишүүн, Н.Ганибал Улсын Их Хурлын гишүүн, Ч.Ундрам Улсын Их Хурлын гишүүн, Т.Энхтүвшин Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа авах чиглэл дээр холбогдох байгууллагаас мэргэжилтэн албан хаагчийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч Х.Ганхуягт зөвшөөрсүгэй. Ажлын хэсгийн зорилго бүрэлдэхүүний талаар өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэн байна? Оюунчимэг гишүүнийг гялс дуудаадхаач ойрхон байсан. Байна уу? Алга байна гээд би тогшигчхсон билүү сая? Тогшсон байх

тийм ээ. Санал хураалт явуулж эхэлье. Томьёоллыг уншъя саналын томьёоллыг.

Хянан шалгах ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолыг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүдээ анхааралтай байгаарай, санал хураалт. Батлут гишүүний санал эсрэг гарсан байна. Батлут гишүүн та санал гаргах уу?

**Д.Батлут:** Энэ би дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгож, ахин санал хураалгаж өгнө үү гэж хүсэж байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Батлут гишүүний төхөөрөмж ажиллаагүй учраас ингээд энэ саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэж санал гаргаж байна. Ингээд энэ саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Үгүй ээ орж ирнэ. Бүгд юу руу орно. Гишүүдийн 63.6 хувь нь дэмжиж саяын санал дэмжигдлээ. Ингээд саяын санал дэмжигдсэнтэй дэмжигдсэн учраас дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 63.6 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

14.35 цаг

**Хоёр. “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай”**

**Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Ингээд дараагийнхаа асуудалд орёе. Хэлэлцэх асуудал 2.Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье. Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн

танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм танилцуулна. Ундрэм гишүүний микрофоныг нээе.

**Ч.Ундрэм:** Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн. Эдийн засгийн байнгын хороо тус тогтоолын төслийг Байнгын хороо чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан. Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм ахалж, Д.Батлут, Н.Ганибал, Х.Ганхуяг, Б.Энхбаяр нар гишүүнээр ажиллалаа.

Ажлын хэсэг хуралдаад гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолоо та бүхэнд хүргүүлсэн. Монгол Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолоор анх удаа төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид 229.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг шилжүүлснээр орон нутгийн өмч бий болсон. Үүнээс хойш 2001-2018 оны хооронд төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Монгол Улсын Их Хурлын 9 удаагийн тогтоолоор эд хөрөнгө шилжүүлсэн шилжүүлж байсан. Энэ удаагийн тогтоолын төсөлд дараах үндэслэл шалтгаанаар хөрөнгө нэмж тусгах шаардлага гарсан.

Сүүлийн жилүүдэд төсвийн хөрөнгөөр авто тээврийн хэрэгсэл худалдан авахыг хязгаарласнаас үүдэлтэй алслагдсан сумдын төрийн үйлчилгээнд автомашин дутагдалтай байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн автомашинаас шилжүүлэн авах

хүсэлтийг төрийн байгууллагууд удаа дараа гаргаж байгаа бөгөөд энэ хүрээнд эмнэлгийн тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор алслагдмал сумдын эрүүл мэндийн байгууллагад автомашин шилжүүлэхээр нэмж тусгах. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар түүний 21 аймаг дахь газруудыг татан буулгасан тул тухайн хөрөнгийг орон нутагт нь ялангуяа автомашин шаардлагатай байгаа байгууллагад нь шилжүүлэх зарчим барьсан.

Иймд автомашиныг тухайн байгууллагуудад урьдчилан үзүүлж, чанар байдлыг шалгах, хэрэгцээнд нь нийцэж байгаа эсэхийг нягтлахад тодорхой хугацаа зарцуулсан. Ингээд хүлээн авах боломжтой гэж үзсэн хөрөнгийг гэрээгээр ашиглуулж байна. Ашиглалтын гэрээгээр орон нутгийн өмчит байгууллагад ашиглуулж байгаа эдгээр автомашин машиныг тогтоолын төсөлд нэмж тусгасан, орон нутгийн өмчид шилжүүлэх шаардлага үүссэн байна.

Дээрх хүрээнд ажлын хэсэг зарчмын зөрүүтэй 39 санал, найруулгын 2 санал гаргасан. Эдгээр зарчмын зөрүүтэй саналаас 30 санал нь автомашиныг тогтоолын төслийн хавсралтад шинээр нэмж тусгах агуулга бүхий саналууд байгаа юм. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийг танилцуулъя. Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Даваахүүгийн Нарангэрэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтсийн дарга байна уу? Батчулууны Мөнхбаатар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Ажлын хэсгийн танилцуулгаас асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү? Оюунчимэг гишүүнээр тасалъя, Цогтгэрэл гишүүнээр тасалъя. Ингээд Батлут гишүүн асуултаа асууя. Батлут гишүүний микрофоныг нээе.

**Д.Батлут:** Юуны өмнө энэ өдрийн мэндийг хүргэе. ТӨБЗГ-ынханд би нэг яг энэ өмч хөрөнгөтэй холбоотой асуудлаар албан тоот өгөөд хариу авч чадахаа байсан. 2022 оны 10 сарын 7-ны өдрийн 03/92 52 дугаартай албан тоотын хариу надад өгөөгүй байгаа. Архив бичиг хэрэгт хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 43 дугаар зүйлд зүйлийг сайн мэдэж байгаа байх гэж бодож байна. Цэнгэл дарга. Хэд хоногийн дотор албан тушаалтанд хариу өгөх ёстой вэ гэж. Тэгэхээр та энэ тухай надад ерөөсөө хариу өгөөгүй байгаа. Ямар учир шалтгаан байгаагаа тайлбарлаж өгнө үү?

Энэ бол уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн дотоод дотоодын цэргийн хамгаалалтад явж байсан 0195 дугаартай автомашиныг хурааж авсан асуудал. Тэгээд энэ дотоодын цэрэг бол онцгой газар. Мөн Орхон аймгийн нийт иргэдийн амь нас, эрүүл мэндтэй холбоотой асуудлыг сахин хамгаалж байдаг газар. Нэг ёсондоо ус ханган нийлүүлдэг тэр дэд станцуудын харуул хамгаалалтыг шалгаж хамгаалж байдаг ийм газар байгаа. Тэгээд энэ уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн баланст байсан энэ машиныг машин нь өөрөө энэ дотоодын цэргийн үйл ажиллагаанд явуулдаг байсан. Тэгээд Хэмнэлтийн үнэ тухай хуульд ч гэсэн заагаад өгчихсөн байгаа шүү дээ. Тэгээд Хэмнэлтийн тухай хуулийн 6.3-д заачихсан байгаа. 6.5.3-д дотоод цагдаагийн албанд ажиллаж байгаа автомашин машин бол тухайн чиглэлээр үйл ажиллагаанд явуулах боломжтой машин тэргийг нь Хэмнэлтийн хуулийн дагуу хязгаарлах боломжгүй гээд заагаад өгчихсөн байтал энэ машиныг хурааж аваад одоо болтол

шийдэж өгөөгүй. Албан тоот өгөөд хариу өгдөггүй. Энийг юу гэж ойлгох юм бэ?

Энэ дотоодын цэргийг би онцолж хэллээ шүү дээ. Манай Орхон аймаг Эрдэнэт хотын 1 нийт хүн амын 40 гаруй хувь нь орон сууцын хороололд амьдардаг. Жилдээ 5.6 сая шоо метр куб ус хэрэглэдэг. Тэр усны хамгаалалтыг хариуцдаг газар. Дотоодын цэрэг өөрөө. Байнгын 65 километр газарт эргэлт тойролт хийдэг, хяналт шалгалт явуулдаг, зам нь бартаатай бас шороон замтай байгаа. Ийм газар явдаг машиныг хураагаад авчихсан ингээд энийг нь буцааж олгож олгож өгөөч гэж бичиг өгөнгүүт хариу өгдөггүй. Тэгээд энэ дээр 1 хариу хариулт өгөөч, энэ машиныг яаж шийдэх юм, шийдсэн юм уу, үгүй юм уу гэдэг дээр.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгээс хариулах уу? Ажлын хэсгийн 5 номерыг нэе. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

**Б.Цэнгэл:** Батлут гишүүний асуултад хариулъя Төрийн өмчийн бодлого, зохицуулах хорооны дарга Цэнгэл байна. Эрдэнэт үйлдвэрээс бид 30-аад машин татсан. Эрдэнэт үйлдвэр бол машин гаргах жагсаалтаа өөрснөө гаргаж өгсөн. Бидэнд бол дотоодын Эрдэнэт Эрдэнэтэд байгаа дотоодын цэргийн энэ машин хэрэглэж байгаа гэдэг ийм тайлбарыг бол манайд бол өгөөгүй. Эрдэнэт үйлдвэр ЗГ-ын шийдвэрээр Эрдэнэс Монгол компани руу шилжчихсэн байж байгаа. Тэгэхээр аливаа Эрдэнэттэй холбоотой асуудал бол Эрдэнэс Монгол руу бол бид материалуудын дунд шилжүүлээд ингээд явж байгаа.

Яг Батлут гишүүний энэ ярьж байгаа асуудлыг бол бид маш яаралтай ингээд судлаад, үнэхээр дотоодын цэрэгт явж байсан машин тэгээд одоо машин тэрэггүй болчихсон ийм асуудал байгаа бол бид энийг яаралтай судлаад

энд бас нааштайгаар нь шийдвэрлэх ийм нөхцөл байдлыг бол бас эргээд бол ярилцаж болох бололцоотой гэж үзэж байгаа.

Яагаад гэхээр зүгээр Их Хурлын бүрэн эрхийн асуудлыг нь бид нар өнөөдөр Их Хурал руу оруулж байгаа. Засгийн газрын шийдвэрээр бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрх хэмжээнийхээ хүрээнд бас шийдвэржиж байж болох тийм бол бас зүйлүүд байж байгаа. Тэгэхээр энийг Батлут гишүүний тавьж байгаа энэ зарчмын шаардлагыг бол зөв зүйтэй, энийг хүлээж авч байна гишүүндээ. Хугацаа алдсан байгаа явдалд бол хүлцэл өчье. Ингээд энийг бид хэд ойрын хугацаанд танд асуудлыг нь бол шийдээд явъя.

Таны нөгөө 1 тавьсан асуудлыг бол хуулийн хүрээнд нь бол ингээд зохицуулаад явж байгаа. Баярлалаа. Тэгье. Танд нэг хариу.

**Ц.Цэрэнпунцаг:** Батлут гишүүн хариулт хангалттай юу? Хариулт хангалттай гэж үзсэн байна. Ингээд Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Цэнгэл дарга уг нь бас төрийн туршилагатай хүн. Сүүлийн үед ингээд хараад байхад 1 л машин нааш цааш нь шилжүүлсэн, энэ машиныг ингэлээ тэглээ энэ бас шударга бус байна гээд л хэвлэл мэдээлэл олон нийтийн хэрэгслээр баахан дайруулсан л 1 ийм юм явц яваад байх юм. Тэгээд Эдийн засгийн байнгын хорооноос энэ Ундрам гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг гарсан байгаа. Гэхдээ энэ ажлын хэсэг хэн Цэнгэл дарга л хариулах байх даа. Энэ машинуудыг чинь аль эрт хуваарилчихсан л байгаад байсан шүү дээ. Тэгээд энэний дараа ажлын хэсэг гараад ямар үр дүнтэй байдаг юм бэ? Тэгээд ямар үндэслэлээр, яагаад энэ машинуудыг ингэж ийш тийш нь хуваарилсан энэ үндэслэлээ та 1 хэлж өгөхгүй юу?



Одоо жишээлбэл энэ засгийн автобааз өөрөө бас төрийн ажлыг явуулдаг хөдөө орон нутаг, гадаадын хүндтэй төлөөлөгчид ирэх бас хариуцлагатай байх ийм газар. Гэтэл өнөөдөр энэ газар нь өөрөө бараг л дампуурах шахчихсан, унаа машин байхгүй гээд л дотроо бөөн хэрүүл уруул байгаа шинжтэй. Таныг ч гэсэн бас эртээд чуулган дээр шүүмжлээд л байсан. Гадуур автомашин ингээд шударга бусаар ил тод нээлттэй шилэн бишээр машин хуваарилж байна гэсэн шүүмжлэлүүд дагаад байна. Сая Батлут гишүүн бас ингээд л яриад байна л даа. Тэгээд уг нь Төрийн өмчийн хороо бол маш хариуцлагатай хийх ажил маш их баймаар.

Нэг талаасаа Төрийн хэмнэлтийн хууль гээд баахан машин цэгцэлж байгаа юм харагдаад байгаа хэр нь нөгөө талаараа тэгээд л баахан ингээд шилжүүлгүүд 1 аймаг дотор эсвэл хотоос 1 дүүрэг рүү, яг бодит нэн шаардлагатай энэ газар энэ тэр нь машин хуваарилагдаж ирээгүй гээд л бид нарт жишээлбэл ийм гомдлууд ирээд л байгаа байхгүй юу. Би тэдэнд унаа залгах байхгүй болчихсон хөл залгах унаа байхгүй, ажил явдаггүй. Тэгээд Төрийн хэмнэлтийн хууль гээд танаад хаячихсан гээд. Энд жишээлбэл бүүр хотын захын дүүрэг дээр явдаг зарим байгууллагуудын хүмүүс нь автобусаар яваад, өөрийнхөө мөнгө гаргаад, тэгээд авсан цалин нь ч байхгүй гээд бараг л ажлаасаа гармаар байна гэсэн төрийн албан хаагчид зөндөө байна гээд л өнөө өглөө хүртэл ингээд л уулзалтад ороход ингээд ярьж байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ дээр бас 1 бодит мэдээлэл өгөөч. Ямар шалгуураар, яаж энэ автомашинуудыг жишээ нь хуваарилаад байгаа юм бэ? Энэ мэдээллийг авъя гэж бодож байна. Ажлын хэсэгтэйгээ яаж тулж ажилласан юм. Ундрам гишүүн ч гэсэн дараа нь хариулах уу? Ажлын хэсэг энэ

машин хуваарилалт дээр үнэхээр зөв юм байна лээ зайлшгүй байна лээ гэж үзсэн үү эсвэл нэгэнт хуваарилагдсан юман дээр дүгнэлт гаргах амаргүй байсан уу? Энэ дээр 1 хариулт авъя.

**Б.Цэнгэл:** Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

**Б.Цэнгэл:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Цэнгэл. Тэгэхээр Оюунчимэг гишүүний ярьж байгаатай бол би бол санал 1 байгаа. Манай дээр бол мянга гаруй машиныг хэрэгцээтэй байна гэдэг хүсэлтүүд бол ирсэн. Энэ бол сүүлийн үед бол нэмэгдэж байгаа. Бид энэ Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу 300 орчим машиныг бол татан төвлөрүүлсэн. Эндээсээ бид нар бол хуваарилалтуудыг хийгээд явсан. Бид өнөөдөр яагаад энэ асуудал дээр ингээд 30 машин өмнөх Засгийн газрын шийдчихсэн асуудал дээр нэмж оруулж ирсэн бэ гэхээр бол өвөлжилт хүндэрсэн аймгуудад нэн ялангуяа Засгийн гарын хурал дээр Эрүүл мэндийн сайд санал гаргаж хүндрэлтэй байгаа аймгуудын Эрүүл мэндийн төвд энэ машинуудыг шилжүүлэх нь зүйтэй гэдэг асуудал гаргаад энийг бол Засгийн газар дээр дэмжээд ингээд бол явсан.

Нөгөөтээгүүр бид мянга гаруй хүсэлтүүд ирсэн гэж сая хэллээ. Эндээс бид тухайн тойргоос сонгогдсон Их Хурлын гишүүд, тухайн аймгийн төрийн байгууллагуудаас ирж байгаа хүсэлт, салбарын яамнуудаас ирж байгаа хүсэлтүүдийг тэргүүн ээлжид бол ер нь анхааръя гэж үзсэн.

Нөгөө 1 асуудалд бол та мэдэж байгаа. Хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заагдсан байгууллагуудад тэрэндээ нөгөө хүчний байгууллагууд энэ тэр, эмнэлэг энэ тэр байж байгаа шүү дээ. Тэр байгууллагууд руу бол тэргүүн ээлжид хуваарилах нь зүйтэй гэдэг Засгийн газрын бас тийм тогтоол бол гарсан, 204 дүгээр тогтоол гэж байж байгаа.

Тэгэхээр бид Засгийн газрын 204 дүгээр тогтоолд заасан тэр зарчмынхаа дагуу энэ асуудлуудыг ингэж эрэмбэлж оруулж ирж шийдэхгүй бол бид хүсэлтүүд их байдаг. Хүн болгоны хүсэлтийг хангах бололцоо байхгүй учраас энэ байж байгаа.

Мэдээж нөгөө 1 асуудал гэх юм бол Мэргэжлийн хяналтын ерөнхий газар бол татан буугдсан. МХЕГ татан буугдаад МХЕГ-ын өмч хөрөнгийг бас дахин хуваарилах асуудал бол Засгийн газрын комисст гараад бол ажиллаж байгаа. Энэ хүрэн дээр бол Засгийн газрын комисс дээр шийдвэр гараад тухайлбал үл хөдлөх хөрөнгийг нь хэрэгцээтэй байгаа аймгуудынх нь саналыг үндэслээд орон нутгийн саналыг нь үндэслээд ингээд хуваарилалтуудыг хийж байгаа. Зарим нэгэн хөдлөх хөрөнгүүдийг нь бол бид нар бас энэ тогтоол дотор орж ирж байгаа зүйлүүд ч байж байгаа. Тэгэхээр ер нь бол нийт гишүүддээ бас хэлэхэд бол бид энэ аймгуудад бол өвөлжилт хүндрэлтэй байсан учраас машинуудыг ашиглалтын гэрээгээр шүү, ашиглалтын гэрээгээр бол бид нар бол машинуудыг нь бол түр ингээд өгчихсөн байж байгаа. Энэ бол бүрэн шийдвэр нь бол гараагүй байгаа. Тийм учраас өнөөдөр Их Хурлаар ороод ингээд энэ шийдэгдчих юм бол бид нар бол машиныг шилжүүлэх ийм процедурыг бол хуулийн дагуу хийгээд явчих юм л гэж та бүхэн маань бас ойлгох ойлгохыг хүсэж байна.

Ер нь 16, 17 оноос хойш төр ерөөсөө парк шинэчлэлт хийгээгүй. Төсвийн байгууллага болон ТӨК-үүд дээр бол ерөнхийдөө бол ихэнх нь дандаа ашиглалтын хугацаа дуусчихсан, элэгдчихсэн ийм тээврийн хэрэгсэл байж байгаа юм. Үлдэх өртөгтэй ийм машинуудыг нь л бид нар Их Хурлын Их хурлынхаа шийдвэр рүү оруулаад төрөөс орон нутгийн өмчид шилжүүлэх асуудлыг бид ингээд хуулийн дагуу оруулж ирж байгаа юм. Ер нь бол бас гишүүд бас өмнө нь бас хэлж байсан. Ер

нь сандал, ширээ ийм машинтай холбоотой асуудлыг Их Хурал руу оруулж ирж байна гэсэн. Бид нар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Засгийн газар, Их Хуралд өргөн барьчихсан байгаа шүү дээ. Тэгэхээр тэрэн дээр бол энэ асуудлууд бол ер нь Засгийн газар шийддэг байдлаар ингээд төсөлд бол явж байгаа. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Оюунчимэг гишүүн асуултаа асуучихсан. Цогтгэрэл гишүүн асуултаа асууя. Энэ ажлын хэсгээс нэмж хариулах уу? Ундрам гишүүн нэмж хариулъя. Манай техникийнхэн Цогтгэрэл гишүүний микрофоныг хаагаад.

**Ч.Ундрам:** Ерөнхийдөө энэ тогтоолын төсөл Улсын Их Хуралд өргөн баригдах үед энэ машинууд бол Засгийн газрын шийдвэрийн дагуу бас шаардлагатай нөхцөл байдлаасаа болоод шаардлагатай байсан учраас энэ орон нутаг руу шилжчихсэн байсан. Тэгээд энэ дээр ажлын хэсэг юун дээр ажилласан бэ гэхээр тухайн орон нутагтаа шилжүүлээд зарим 1 машиныг нь бол машин нь бол нэлээн хуучирчихсан, шаардлага хангахгүй байна гээд буцаах ч юм уу, энэ сумандаа биш ийшээ нь авах нь зөв байсан юм ч гэдэг юм уу гэх мэтчилэн нэг ийм гуч орчим машины нааш цааш үнийн дүнгийн зөрүү гээд тиймэрхүү юмнууд дээр нь нягталж ажилласан.

Тэгээд ер нь бол цаашид бид нар энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн барьчихсан байгаа юм байна лээ. Энийг яаралтай авч хэлэлцэхгүй бол ийм жижиг сажиг хуучин тавилга, эд хогшил, машины шилжүүлгийг Их Хурал бол ингээд хэлэлцээд байх нь бас зохисгүй юм гэсэн асуудлыг ажлын хэсэг дээр бас бид нар ярьсан байгаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Оюунчимэг гишүүн нэмэлт асуулт асууя.

**М.Оюунчимэг:** Тэгэхээр цаашдаа бол удахгүй цэгцлэгдэх юм байна гэж би ойлголоо. Тэгээд Цэнгэл дарга энэ нөгөө хуулийн хэлэлцүүлэг ард түмнээсээ асуухаар энэ Байнгын хороодын референт ажилтнууд, Тамгын газрын ажилтнууд, гишүүд хөдөө орон нутаг хот хөдөөгүй нэлээд их явж байна. Гэтэл баазын энэ автомашинууд чинь ямар ч засвар үйлчилгээнд мөнгө төгрөг ч тавихаа байчихсан. Ер нь энэ авто бааз чинь жсоохон хэцүүхэн байгаад байгаа юм биш үү? Та өөрөө Төрийн өмчийн хорооны мэдэлд ирсэн, жсоохон анхаарч энэ дээрээ явахгүй бол бас энэ чинь болохгүй шүү дээ. Төрийн бас ганц авто баазын энэ асуудал байгаа. Тэгээд жолооч нар нь ч бүүр үг хэлж чадахаа байчихсан 1 тийм байдалтай байгаа юм байна лээ. Тэгээд та энэ дээр анхаараарай гэж хэлье. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Санал хэлчхэв үү? Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

**О.Цогтгэрэл:** Түрүүн тэр ажлын хэсгээс бас хариултууд бас гарч байна. Миний асуух гэж байсан зүйл энэ одоо яг Их Хурал дээр энэ 1 баахан сандал ширээ хориод жил болчихсон фургоньг хаашаа шилжүүлэх вэ гээд. Тэгээд зарчмын зөрүүтэй санал гээд 30, 40-өөд юм гарчихсан. Яг гишүүд энийг нь уншиж мэдэж байгаа ч юм байхгүй ингээд л. Энэ чинь бүүр төрийн ажлын нөгөө дэс дараа нь байхгүй болчихсон, дээшээгээ нэгдсэн төвлөрөл төвлөрлийг сааруулах биш төвлөрөл гэдэг юм бүр агентлагаасаа даваад Засгаасаа даваад Их Хурал руу нь энэ асуудал нь ороод ирж. Энэ чинь засаг нь байтугай тэгээд ТӨБЗГ нь өөрөө энэ асуудлаа шийдээд, энийг нь засаг болоод дээрээсээ бодлого, хууль, дүрэм журмынхаа хүрээнд хариуцлагаа хүлээгээд эрхээ эдлээд л явах ёстой.

Тэгэхээр энэний цаана их л олон ийм л юм л явж л байгаа юм байна л даа. Тэгээд тэр Төрийн болоод орон нутгийн өмчийн тухай хууль дээр л энийг яаралтай засах шаардлагатай л зүйл

байна. Энэ бол үнэхээр бас ингээд тал талдаа ажлыг бид нар зүгээр хэлбэрдэж байна шүү дээ. Энд байгаа энэ зүйлийг энэ furgоньг шилжүүлэх юм уу, үгүй юу гээд энд санал хураана гэдэг чинь ямар ч утга учиргүй. Тэгээд энэ дээр судалж, энэ ер нь тийм. Тэгэхээр түрүүн бас ажлын хэсгээс гарч байх шиг байна. Энийгээ яаралтай л анхаарахгүй бол.

**Ц.Цэрэнпунцаг:** Та санал хэлчхэв үү ерөнхийдөө. Хариулах уу? Ундрам гишүүн хариулъя.

**Ч.Ундрам:** Ер нь бол Оюунчимэг гишүүн, Цогтгэрэл гишүүдтэй санал нэг байна. Тэгээд бид нар гол нь яг хуулиа л дагаж байгаа гэсэн үг. Тэгээд хуулийнхаа дагуу энэ асуудлыг яалт ч үгүй ажлын хэсэг байгуулаад ингээд ажиллаж байна. Гэхдээ өнөөдөр энэ Байнгын хороо дээр энэ олон саналыг жижижхэн машин тус бүрээр нь хураалгасны оронд багцлаад маш цөөхөн санал хураалгах ийм боломж бол байгаа юм байна лээ. Тэгээд цөөхөн багцалж саналаа хураагаад, чуулганд оруулах юм бол бас Их Хурлын гишүүдийн бас цагийг хэмнэх боломжтой юм болов уу гэсэн ийм саналыг Байнгын хороонд оруулж байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Тэгэхээр байна шүү дээ наадах чинь дэг бид нар зөрчсөн болох байх. Тэгэхээр би ерөнхийдөө нэг ийм юм байна. Энэ, Батлут гишүүн та түр суугаадах. Ингэе бид нар энд чинь уул нь нөгөө бодлого гээд айхтар юм яриад сууж байх ёстой биз дээ. Тэгээд ийм, ийм сандал ширээ ингээд машин тэрэг хэмхэрсэн, хэмхрээгүй нэг ийм юм яриад энд сууж байхгүй. Ингээд энэ бараг 40 хэдэн зарчмын зөрүүтэй саналтай ийм баахан санал хураасан ийм ажил бид нар хийхгүй. Энийг буцаая. Буцаагаад та нар энэ саналуудаа энд оруулж ирж нэгтгэж оруулж ирээд, дахиад буцааж өргөн барьсан нь дээр байх тэгэх үү?

Ингээд энийг буцаая. Бүгдээрээ санал хураачихъя. Би ийм горимын санал

гаргаж байна. Энэ буцаачихъя. Буцаачихсан нь дээр юм байна. Энэ бид нар энэ 30, 40 хэдэн энэ зарчмын зөрүүтэй саналууд дээр. Энэ тэгээд дандаа ч 40 хэдэн зүйл нь юу байна гээч, юу байгаа билээ? Бид нар ийм юм яриад сууж байх энэ энд сууж байж хайран л цаг байна шүү дээ. Ийм байна. Тийм учраас санал хураалт явуулъя. Саяын миний буцаая, хууль санаачлагчид нь буцаая гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт, гишүүдээ анхааралтай байгаарай. Гишүүдийн 54.5 хувь нь дэмжснж, ингээд энэ төслийг хууль санаачлагчид нь буцаалаа. Санал хураалт явуулж дууслаа.

Ингээд төрийн өмчөөс Эдийн засгийн байнгын хорооны ингээд энэ өнөөдрийн Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудал үүгээр дуусаж байна. Ингээд хуралдаанд идэвхтэй оролцсон. Үгүй ээ юу гэж байхгүй шүү дээ. Энэ уучлаарай гишүүдээ энэ төрийн санал, дүгнэлт унших ёстой юм байна шүү. Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Ингээд тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулна.

14.57 цаг

Ингээд өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөлөө. Хуралдаанд оролцсон, идэвхтэй оролцсон гишүүдээ баярлалаа. Ажлын хэсэг явж болно.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА